

## ХIII-XIV ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН ХУВЦАСНЫ ХЭЭ УГАЛЗНЫ ТУХАЙ АСУУДАЛД

*Б.Төгсөө, дэд профессор, ӨМБИС*

### Abstract

Mongolian masters, traditionally adhered the nomadic pastoral lifestyle and thinking, have been creating the unique patterns and ornaments which deeply express the aesthetic and artistic thinking of Mongolian nomads in the world. Historically, the patterns and ornaments, inherited from the Mongolian great ancestors, were the significant expressions of Mongolian lifestyle, courage, thought pattern, commonsense, and of their behaviors as well. While creating the patterns and ornaments, Mongolian masters used to plan their drawing sketches based on their own artistic skills, styles, and images, as well as on their traditions and customs. Also, they tried to express their best wishes, symbolic meanings, life and energy, and inspirations in patterns and ornaments. The paper does not intend to comprise all the issues related to the origins, shapes and symbolic meanings of patterns and ornaments, however, it tries to show how those selected patterns and ornaments in Mongolian Arts have been gradually developed and traditionally enriched. Moreover, the study suggests that it is necessary to firmly adhere the artistic thinking styles, people's behaviors, and the symbolic orders and meanings for the creation of miraculous ornaments and patterns.

### Түлхүүр үг

Монгол дээл, Юань гүрэн, торгоны хээ, хээ угалз, дүрслэл

Монголчууд нэн эртнээс нааш нүүдлийн мал аж ахуйг эрхлэн, Төв Азийн эрс тэс уур амьсгалтай, өргөн уудам нутагт нүүдэллэн амьдарсаар ирэхдээ голлон эрхэлдэг аж ахуй, газар орны байдал, цаг уурын нөхцөл зэрэг олон талт хэрэгцээ шаардлагад нь нийцсэн үндэсний хувцсыг бий болгон үеэс үед уламжлан хөгжүүлсэн нь төрөл зүйл, хэлбэрийн хувьд улам бүр баяжин боловсорч, тасралтгүй хувьсан өөрчлөгдсөөр иржээ. Аливаа угсаатан, үндэстний хувцас нь тухайн ард түмний угсаа гарвал, нийгмийн хөгжил хувьсал, үндэсний ухамсар, түүх уламжлал, зан үйл, гоо сайхны таашаалыг нэвт шингээсэн байдгаараа нийгэм, түүх, уран сайхны маш гүн гүнзгий үндэс, суурьтай соёлын өв юм. Тийм ч учраас тухайн нэгэн түүхэн үеийн хувцасны загвар, хийц нь цаг үеийнхээ оюуны болон эдийн соёлын бодит, шууд тусгал болж, нийгмийн үнэлэмж, хэрэгцээ сонирхол, соёлын хөгжлийн хандлага, гоо зүйн мэдлэгийн түвшинг тодорхойлж байдаг аж. Монгол үндэстний хувцсанд ард түмний уран сэтгэлгээ, урлаг арга барил, гоёл чимэглэл, өнгө зохируулах ёс, утга бэлгэдэл гээд уран сайхны соёл, уламжилж бүрэлдсэн гоо ташаал бүхэлдээ биеллээ олсон байна.

Нийгэм соёлын бүхий л салбар хүрээнд өвөг дээдсийн маань өнө эртнээс цогцлуулан бүтээсэн, бүтээсээр яваа аливаа юмсын ил болон далдын шүтэлцээ, шууд болон дамаарлаар төгөлдөржин боловсорч ирсэн дохио тэмдгийн тогтолцоот цаглашгүй үнэт соёлтой түүхт үндэстний хувьд Монгол үндэстний өдөр тутмын амьдрал, найр наадам, шашны аливаа зан үйлд хээ

угалзын зүйл маш элбэг тохиолддог. Хээ угалз нь тухайн үндэстнийхээ ард түмний амьдралын үнэт зүйл, зориг санаа, сайн сайхан хүсэл эрмэлзлэлийг илэрхийлж байдаг төдийгүй тухайн үндэстний соёл урлагт гүн тусгалаа олсоор иржээ. Монгол ардын хээ угалз нь үеэс үед уламжлагдахдаа цаг үе, нийгмийн амьдрал, нийтлэг үзэл санаа, зан үйлийн онцлогтой нягт уялдан хөгжиж, утга бэлгэдэл, хэлбэр дүрс, бүтэц тогтолцоо нь тасралтгүй баялагжин боловсорч ирэв. Анхлан ард түмний өдөр тутмын амьдралын гоо сайхны хэрэгцээ шаардлагатай уялдан бий болж, тэдний сайн сайхан, зол жаргалангийн хүсэл эрмэлзлэлийг тусгасан, утга агуулгаар нэн баялаг ардын урлалын зүйл тул Монгол үндэсний хувцсыг үндэсний хээ угалзаас ангид үзэх боломжгүй нэгдмэл болтлоо уялдан хөгжсөн байна.

Монгол орны хадны зурагт тамга тэмдэг, ан амьтан, хүн, зэр зэвсэг, гэр сууц, тэрэг унаа зэрэг олон зүйлсийн дүрслэл маш элбэг байдаг ба хээ угалзын дүрслэл нэн ховор боловч дүрсэлсэн хээ угалз нь бидний өвөг дээдсийн үйл сэтгэлгээнд хээ угалзын эзлэх байр суурийг илтгэж байна.

### Зураг 1

Хүрэл зэвсгийн үеийн хадны зураг



Зураг 2

Шинэ чулуун зэвсгийн үеийн хадны зураг  
Мөн бид өнөөг хүртэл судлагдаад байгаа




хадны зургийн дурсгалуудыг сэдэв, агуулгын хувьд нэгтгэн үзээд, хадны зураг бол чимэглэлийн үүрэгтэй биш, үйл явдлыг дүрсэлсэн хүүрнэлийн шинжтэй болохыг хялбархан дүгнэж болно.

Харин буган чулуун хөшөөнд сийлсэн дүрслэлийн зохиомжийн бүтэц, хэмнэл, олон хувиралт, уран хэтрүүлэгт, угалзарч матиралдсан дүрслэл нь нэн чимэглэлийн шинжтэй байсныг мэдэж болно.

Зураг 3

Хойд Тамирын голын хөндийн хээ чимэглэл бүхий бүстэй буган хөшөөд.




Эх сурвалж: Гантулга Ж., Ерөөл-Эрдэнэ Ч., Магай Ж. 2016, х.35

Буган хөшөөг өөд болоочийн дурсгалд зориулан босгодог байсан нь тодорхой хэдий ч тэдгээрийн учир холбогдол, бэлгэдлийн талаар судлаачид харилцан адилгүй байр суурьтай байдаг. Буган хөшөөнөө тохиолдох нийтлэг дүрслэлийн нэг нь бүс юм.

Гадаад, дотоодын олон судлаачид буган хөшөөний бүсний дүрслэлийг нарийвчлан хөөж, түүний хувьсал өөрчлөлт, бэлгэдлийг судалсан байдаг ба дүрслэлийг хувьд “ромбо буюу чон хэлбэрийн хээтэй, ханан хээтэй, гурвалжин буюу уулан хээтэй, цэг буюу товруу чимэгтэй, тагнай хэлбэрийн хээтэй, босоо шулуун зураасаар чимэглэсэн, шулуун цулгуй бүс” (Баярсайхан, 2011, х.37) гэж 7 бүлэгт ангилсан байна. Үүнийг зурагт үзүүлбэл дараах байдалтай:

Зураг 4

Буган хөшөөн дээрх бүсний хэлбэрүүд.  
(Баярсайхан, 2011, 38)



Бүс нь нүүдэлчдийн өдөр тутмын амьдралын хэрэглээ төдийгүй дайчин цэрэг эрсийн алдар гавьяа, зэрэг дэв, нийгэмд эзлэх байр суурийг илтгэсээр ирсэн чухал хэрэглэгдэхүүн юм. Тиймээс ч өвөг дээдэс маань тэр олон хувцас эдлэл дундаас бүсийг ийн онцгойлон дүрсэлсэн боловуу. Ганц буган хөшөөн дурсгал ч биш, эртний нүүдэлчдийн булш оршуулгаас биет байдлаар олддог бүс, бүсний үнэт чимэглэлүүд үүнийг давхар баталдаг. Зөвхөн буган хөшөөнд ийм олон зүйлийн хээ бүхий бүс дүрслэгдсэн байгаагаас харахад бидний өвөг дээдсийн хувцас засал хэчнээн гоёмсог, төрөл зүйл олон, хээ угалзаар баялаг байсныг таамаглаж болно. Тэгвэл чулуун хөшөөн дээр яагаад заавал бугын дүрст хээ угалзыг сийлэн дүрслэв гэвэл, эртний овог аймгууд дотор бугыг тотемоо болгосон овог аймгууд цөөнгүй байсан нь археологийн баримтаар батлагддаг бөгөөд дайчин эрс, дээдэс язгууртнууд нь бугын хэлбэр дүрсийг бие дээрээ шивж, зэрэг дэс, баян чинээлэг байдлын илэрхийлэл болгодог байснаас хээ угалзаар биеэ гоёж, түүгээрээ зэрэг зиндаагаа илтгэх ёс нь нэн эртний уламжлалтай бөгөөд яваандаа хувцас хунараа гоёж чимэглэх мэтээр улам хөгжсөн болохыг харуулж байна. Үүгээр Монголчууд нэн эртнээс элдэв зүйлийн хээ угалзаар чимэглэсэн хувцсаар гоёдог төдийгүй, тэдгээр нь гүн утга агуулга, ач холбогдолтой байсан нь нотлогдож байна.

Хувцас, чимэглэлийн зүйлс нь тухайн ард түмний гоо сайхны таашаалыг маш тодоор илтгэн харуулдаг онцлогтой бөгөөд түүгээр дамжуулан бид уламжлалт уран сайхны сэтгэлгээний хэв маяг, урлах арга барил, ардын зан үйлийн онцлог, аж байдлын төлөвшил хувирал гээд олон зүйлийг таньж мэдэх бүрэн боломжтой юм. Оршин буй газар орны байдал, уур амьсгал, үндэстэн угсаатны түүх, шашин соёл, ардын зан заншил, нийгмийн бүтэц, эрхэлдэг аж ахуй зэрэгтэй нь уялдан тухайн үндэстний хувцас зүүсгэлийн хэлбэр маяг, шинж чанар бүрэлдэн тогтсон байдаг. Тиймээс Монголчуудын хувцас зүүсгэлийн хэлбэр дүрс, хэмжээ харьцаа, өнгө үзэмж, гоёл чимэглэлээрээ бусад үндэстэн угсаатнаас ялгарахуйц онцлогтой

хөгжин хувсаж иржээ. Түүнчлэн найр хурим зэрэг ёслол хүндэтгэлийн зан үйлд оролцохдоо нийтээр хүлээн зөвшөөрсөн хувцас заслын нарийн дэг ёс, гоо зүйн хэм хэмжээг баримталдаг байсан ба түүгээрээ зэрэг дэв, удам угсаагаа илтгэн харуулдаг гоёл заслын өндөр соёлыг олон зуунаар хөгжүүлж иржээ. Ялангуяа нийгмийн ноёрхогч анги болох дээдэс язгууртнууд дэргэдээ гарын ур, ухааны ураар олноос шалгарсан урчуудыг цуглуулж, өөрсдийн таашаалд нийцэж, бусдаас онцгойрсон хувцас, чимэглэлийн загвар хийцийг гаргуулан, эдийн сайн, эрдэнэсийн дээдээр урлуулж, эрх ямба, нийгэмд эзлэх байр суурь, хөрөнгө бэлийнхээ илрэл болгон өөр хоорондоо сайрхдаг байжээ.

XIII зуун бол Монгол хувцас заслын урлагийн түүхэн дэх онцгой хувьсал өөрчлөлт гарсан цаг үе юм. Улс төр, эдийн засгийн огцом хурдтай хөгжил нь соёл боловсролын харилцааг өндөр хэмжээнд хөгжүүлсэн ба хувцасны засал чимэглэлээс нь тухайн үеийн Монголчууд эд баялаг, оюуны санааны өндөр түвшинд хүрснийг харж болно. Их хаад тухайлбал, “Мөнх хаан (1252 онд), Хубилай хаан (1275 онд) тайлга ёслолын хувцасны дүрэм хуулийг удаа дараа гарган хэрэгжүүлсэн” (Нямбуу, 2002, х.10) бөгөөд чингэхдээ хуучин хэлбэрийг авч, чимэглэлийг их болгосон байна. Уламжлан ирсэн баруун энгэр давсан дээлийг зүүн энгэр болгон хуулиар баталж, төрийн албатны хувцас засалд хэм хэмжээ тогтоож, зэрэг дэсийн ялгааг нарийн чандалсан байна. Тухайлбал, “хааны ёслолын малгайг үнэт торгоор бүрж, тойруулан сувд хэлхэн үүлт луун хээ урлан хүрээлж, сувд, алт шигтгэх суурийг пийцүү чулуун хонгиогоор тор мэт даран оёно. Мөн үзүүрт нь сувд, алт, пийцүү чулуугаар гоёсон урт унжлага, оройд нь луу хээ сийлсэн хаш хатгуураар чимэглэх ба тэдгээрийн суурь нүхийг тус бүр хаш чулууг сийлж үйлдсэн байна” (Нямбуу, 2002, х.12) гэхчлэн хувцас, зүүсгэл тухай бүрийг нарийвчлан тодорхойлжээ.

Юань улсын үед төрийн өндөр албан тушаалтнууд ёслол хүндэтгэлийн үед өмсдөг зүсэм хувцас гэж байсан тухай түүхэн тэмдэглэлд дурджээ. Тодруулбал, “Хааны өвлийн зүсэм хувцас нь арван зүйл бөгөөд голдуу алтан хоргой, хилэн даавуугаар урлана. Ингэхдээ тухайлбал, улаан, ягаан, хүрэн, хөх, ногоон өнгийн дээл өмсвөөс алтан хоргой малгай хослуулах, цагаан буюу саарал үстэй дээл өмсвөөс цагаан алтан цардмал дуулга өмсөх, цагаан хэрмэн хувцас өмсвөл цагаан хэрмэн дах нөмрөх, гэхчлэн хослуулах нарийн дэгтэй байсан аж. Зуны зүсэм хувцас нь арван таван зүйл. Мөн л сувдан чимэглэлт дээл өмсвөөс сувдаар ороосон үүл малгай өмсөх, тэмээний өнгөт бараан тэрмэн дээлэнд мөн өнгийн малгай хослуулах, их улаан, хөх, ногоон, мөнгөн бор,

цагаан бор зэрэг алтан хатгамал луут дээлэнд алтан гардийн оройд малгай хослуулах, алтан хээтэй, хар цэмбэн залгамал дээлэнд долоон эрдэнэт хар шаа бүстэй, хойтдоо саравчтай малгай өмсөн” (Нямбуу, 2002, х.38-39) гэх мэт нарийн дэгтэй.

#### Зураг 5

“Хубилай хаан анд явж байгаа нь” зургийн хэсэг. (Зурган дээр “Энэхүү зургийг 1280 онд Хааны хувцас хэрэглэлийн албаны түшмэл Лю Гуан Дао хүндэтгэлтэйгээр бүтээв” гэсэн бичээс бий)



Хааны хувцас хэрэглэл хариуцсан түшмэл зураач хүн байсныхаа хувьд тухайн үеийн хүмүүсийн хувцасны загвар хийц, материал, хээ угалз зэргийг туйлын ончтой, нарийн дүрсэлсэн нь Юань гүрний үеийн хувцас заслын тухай бидэнд үлдсэн туйлын чухал судалгааны хэрэглэгдэхүүн болсон.

Түшмэдийн зүсэм хувцас мөн л өвөл, зуны хоёр янз байх ба аль өнгийн, ямар дээл хэдэн зах байхыг тогтоож, “тэргүүн дэсийн түшмэд ганц хүйт их цэцэг, дэд дэсийн түшмэд ганц хүйт бага цэцэг, гутгаар дэсийн түшмэд салаа навчгүй тархмал цэцэг, дөрөв, тав, зургаа, долдугаар дэсийн түшмэд элдэв жижиг цэцэгс хатгаж урласан дээл гэхчлэн зэрэг буурах тусам хээ чимэглэл нь жижгирсээр, хамгийн доод дэсийн найм, есдүгээр дэсийн түшмэд ямар ч хээ угалзгүй цулгуй дээл өмсөнө. Түшмэд бүгд улаан сураар үйлдэж, хаш чулуу, эвэр чимэгтэй толин бүсээр гоёх ба тэргүүн зэрэгтэн шулуун буюу хээтэй хаш тоногтой, дэд дэсийн түшмэд хээтэй хирсний эвэртэй, гурав ба дөрөвдүгээр дэсийн түшмэд шар алтаар луун нүд хийсэн, түүнээс доод дэсийн түшмэд хар хирсийн эвэр чимэгтэй бүс бүсэлнэ” (Нямбуу, 2002, 40) гэхчлэн чимэглэл сэлт, хээ угалзын зүйлээр зэрэг, дэс, албан тушаалыг сайтар ялган, нарийн дүрэмлэн тогтоосон байна. Энэчлэн ёслолын, албаны, цэргийн дээл хувцас нь зориулалтаараа ялгаатайн дээр, мөн чимэглэлийн хээ угалзаараа ялгарч, тэр нь зэрэг дэсийг ялгах гол таних тэмдэг болж байсан байна.

Энгийн ардын дээл нь хуульчлан тогтоосны дагуу “зөв энгэртэй, энгэр нь дөрвөлжин мөөрөлжин хэлбэртэй, өргөн сугатай, бугалгаараа нарийн ханцуйтай” (Саруулбуян, нар, х.15) байв.

#### Зураг 6

Дани улсын Копенгагений Давидын музейн цуглуулгад хадгалагдаж буй XIII-XIV зууны эрэгтэй, нолом торгон дээл. (Нолом-Алтан утсаар хатгаж хийсэн хоргой мэт торго. Одоогоор судлаачид яг монгол дээл гэж тогтоогүй боловч, хийц хэлбэрийн хувьд Юанийн үеийн монгол дээлтэй тун адил төстэй байна.)



#### Зураг 7, 8

Эрэгтэй дээл. XIII-XIV зуун



Дундад зууны Монголчуудын тэрлэг нь хэлбэр загварын хувьд язгууртан, харц, эрэгтэй, эмэгтэй ерөнхийдөө адилавар боловч, материал болон хээ угалзаараа зэрэг дэсийн ялгаатай байв. Өмнө нь ихэвчлэн бүдүүн цэмбэ, сайтар боловсруулсан арьсан дээл өмсдөг байснаа гадаад худалдаа наймаа өргөжиж, эд таваар арвихихын хирээр элдэв зүйлийн өнгийн, хээтэй, хээгүй бөс, торгоор дээл урлаж, голчлон нар, сар, луу, гарьд, цэцгэн хээг ихэвчлэн алтан утсаар хатгаж өмсдөг болжээ.

Ноёд нь луу гарьд мэт хүчтэн, жигүүртний дүрийг торгон дээл дээр хатгаж гоёдог бөгөөд булга зэрэг ховор ангийн арьс үс, тогос зэрэг жигүүртний өд сөдөөр чимэглэн засаж, хээ угалзын сүрлэг дорвилог, түүний гүн утга бэлгэдлээр эгэл ардаас ялгарна.

Доод түшмэд, зарц, эгэл бор ардууд том, сүрлэг хээ угалз хэрэглэдэггүй бөгөөд өвс ороомол мэтийн жижиг хээ угалз бүхий нэхмэл бүсээр тэрлэг оёж өмсдөг. Язгууртын хувцсыг хийх үнэт торго сэлтийг ихэвчлэн Хятад, Перс, Самаркандаас авчирдаг тул өмнөд болон дундад Азийн хэв маяг бүхий торго дурдан нэлээд дэлгэрч, хээ угалз нь түүнийг дагалдан Грекийн үлгэр домгийн сэдэвт амьтны загварт хээ угалз зэрэг нэн өвөрмөц зүйлээр баяжсан байна.

#### Зураг 9

Галт шувуу, луун хээт торго. Юань гүрэн.



Юань улсын үед нийгэм соёлын бүхий л салбарт хурдацтай дэвшил гарч, бүхий л талын худалдаа үйлдвэрлэлийг улсын бодлогоор хэрэгжүүлж байсны дотор “алт, мөнгө, сувд, хаш олборлон боловсруулах газар, том том алт, мөнгө, чулуун дархны газар, хөвөнгийн ургамал тариалж, боловсруулах газар, нэхмэлийн гар үйлдвэр, эсгий хивс нэхэх гар үйлдвэр зэрэг улсын болон хувийн үйлдвэр, худалдааны газрууд үйл ажиллагаа явуулж байсан” (Ганболд Ж., нар, 2006, 72-80) нь хувцас заслын урлагт багагүй өрсөлдөөн байсныг харуулаад зогсохгүй, тухай үеийн хувцасны өнгө төрх, хийц урлалд зохих нөлөө үзүүлсэн нь гарцаагүй. Үүнийг ч археологийн олдворууд баталдаг.

Зураг 10, 11, 12  
Юань гүрний үеийн торго



Юань гүрний үеийн эмэгтэйчүүд ихэвчлэн зүүн энгэрийн, уужим, урт дээл, ууж, дах өмсдөг бөгөөд дээлний их биеийг голлон улаан, ногоон, шар, шаргал, бор өнгийн, цэцэг навч, эрвээхий, шувуу зэргийн жижгэвтэр хээ бүхий торго дурдангаар урлаж, захыг нь хар бараан өнгийн гоёмсог торгоор өнгө ялган хийж, алтан утсаар хээ хатган чимэглээд, зөөлөн торгон бүс бүсэлдэг байжээ. Язгууртан эмэгтэйчүүд нь цаас цардаж эсвэл, хулс модны хальсаар үйлдэж, улаан, улаан хүрэн голдуу өнгийн торго дурдангаар өнгөлж, ар өвөрт нь цэцэг навчин хээ угалз хатгаж шаглаад, шүр сувд мэтийг суулгаж, оройд нь тогосын өд хатгасан малгай өмнө.

Зураг 13  
Эмэгтэйчүүдийн дээл. XIII-XIV зүүн



Зураг 14  
Бортого малгай



Эмэгтэйчүүдийн толгойн засал сэлт болон дээл хувцсыг ихэвчлэн торго дурдан, мяндсаар оёж, тогоруу, эрвээхий, гарьд, буга, туулай, тарвага, загас, мэлхий, усны долгион, лянхуа цэцэг, тоорын цэцэг, ороомол өвс, ургамал жимсний дүрст хээ угалзаар, зарим хэсэгт нь үүлэн хээ зэрэг байгалийн үзэгдлийн дүрсийн гаралтай хээ угалзыг хослуулан чимэглэдэг байв. Хэв маяг, дүрс байдал дахин давтагдашгүй өвөрмөц бөгөөд туйлын хөдөлгөөнтэй, амьдлаг нь тухайн үеийн гар урчуудын сэтгэлийн ур, гарын урыг илтгэн харуулдаг. Түүхэн баримтаас үзэхэд хээ угалзын урлаг нь хувцас заслын болоод бусад урлагт чиглүүлэх нөлөөтэй байсаар иржээ хэмээн дүгнэж болно. Хувцас заслын урлагт монгол хувцасны уламжлалт бүтэц хэлбэр, загвартай нягт уялдсан, жигд, цэгцтэй, зохицолт, тэнцвэрт хээ угалзын гүйцэтгэлийг шаардаж байв. Монгол хувцасны төрлүүд, тэдгээрийн бүрдэл хэсгүүдэд өөр хоорондоо ялгаа бүхий маш олон төрлийн хээ угалзаар гоёж чимэглэсэн байдаг. Судлаачдын тогтоосноор тухайн үед 100 илүү төрөл зүйлийн хээ угалзыг түгээмэл хэрэглэж байжээ. Жишээлбэл, эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхэд, настайчуудын дээл, тэрлэг, малгай, гутал, ууж, алба, ямбаны, цэргийн, ёслол хүндэтгэлийн хувцас зэрэгт утга бэлгэдэгийг нь дүйцүүлж, хээ угалзны хэлбэр дүрс, өнгө зохирлыг тааруулдаг нарийн дэг ёс тогтоод байсан нь “ямар ч зүйлийг жирийн нэгэн чимэг гоёл бус гүн агуулга санаа оруулан урладаг байсан жинхэнэ утга төгөлдөр, уран сайхны нарийн шаардлагыг хангасан, нүүдэлчдийн нэгэн сонгодог урлаг болтлоо хөгжсөн”-ий илрэл юм (Батчулуун, 1999, х.208).

Ялангуяа ихэс дээдэс, өндөр тушаалын ноёд, түшмэдийн дээлний энгэрийн хээний утга бэлгэдэл нь гүн гүнзгий, ур хийц нь чамин тансаг,

сүрлэг бөгөөд дахин давтагдашгүй өвөрмөц содон байдаг. Эдгээр хээ угалз нь дээлний гол чимэглэл болж, дээлний ерөнхий бүтэц, зохицолт чанарыг улмаар тодруулан, гол ба дэдийн харьцаатай болгосон байна. Дээлний хээ угалз нь дүрс хэлбэрийн хувьд өвөрмөцийн дээр ороох, хатгах, наах, сийлэх, сүлжих зэрэг олон аргыг хослуулсан тун нарийн хийцтэй. Монгол дээл хувцасны хэлбэр загвар, хээ чимэглэл нь овог аймаг, газар орны байдлаараа өөр хоорондоо ялгаатай боловч бүхий л хээ угалзын хэв дүрс, зохиомжийн арга хэлбэр, хослол зохирол нь эртнээс уламжлагдан ирсэн хээ угалзын үндсэн хэв маяг, бүтэц, гоо сайхны хэм хэмжээгээрээ нарийн нэгдэлтэй байсаар иржээ. Энэ нь бидний урлагт “Дорнын нүүдэлчдийн уламжлалт сэтгэлгээнд тулгуурласан, тойрон буй орчноо ухааран ойлгох бүх тогтолцоот үзлийн нэгдэл болсон уран сайхны ёс дэгчилэх зарчим хэрэгждэг”-ээр тайлбарлагдана. (Сарантуяа, 1999, х.98-99)

Зураг 15, 16

Монгол язгууртны зээгт наамалтай дээл. XIII-XIV зуун



Хэнтий аймгийн Бухын хошуунаас гурван ч дээл олдсон байдгийн нэг нь энэхүү язгууртны дээл юм. Мөрөн дээрээ маш нарийн хийц бүхий зээгт наамалтай, ханцуйгаараа нарийхан, бүсэлхийгээрээ олон ширээстэй, ташуу энгэртэй энэ мэт дээл ерөнхийдөө Киданы үеэс түгээмэл хэрэглэгдэх болсон гэж судлаачид үздэг ч бидэнд мэдэгдээд байгаа XIII-XIV зуунд хамаарах маш олон олдворууд ерөнхий эсгүүр, хийц, хээний ерөнхий зохиомж, захыг голлуулан мөр, чээж, нурууг бүхэлд бүрхсэн тэгш хэмт угалз, ташаа хормойны хүрээг дагасан үргэлжилсэн хээ, ханцуйны хээ зэргээрээ ихэд төстэй, эсвэл яг

адил биш юмаа гэхэд эдгээр хэсгээр эмжсэн эмжээр болоод чимэглэж урласан хээний өргөн, харьцаа зэргээрээ тун адил төстэй байгаа юм. “Аливаа хээ бэлгэдэл бүхнээ ёс заншлын нарийн ухагдахуунаар амьшуулж, амьтанчилж, хүнчилж дүрслэн, утга бэлгэдлийг нь ёсчлон сахиж ирснээс ямар ч төрийн үед ач холбогдлоо алдалгүй, улам бүр баялагжихын үндэс болсон” (Батчулуун, Л. 1999, 215) нь тухайн үеийн дээл хувцасны хэлбэр загвар, өнгө зохирол, ур хийц, гоёл чимэглэл зэрэг нь тухайн үндэстний гоо сайхны таашаал, уран сайхны сэтгэлгээ зэрэг онцлог хэв шинжийг илтгээд зогсохгүй, хувь хүний нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлох хэмжээний гүн агуулга, ач холбогдол бүхий болтлоо хөгжсөнөөс харагдаж байна.

## Дүгнэлт

Нэн эртний домгийн сэтгэлгээний үндэстэй дохио тэмдэг, хээ угалзын тогтолцоот урлагийн хэв шинж манай үндэстний урлагт ямагт хадгалагдсаар ирсэн ба үеэс үед ур хийц, утга бэлгэдэл, төрөл зүйлээр улам бүр баяжсаар байсан нь Монголын нийгэм соёлын их мандалтын үе буюу Их эзэнт гүрний үеийн дурсгалаас тод харагдаж байна.

XIII-XIV зууны Монголчуудын дээл хэлбэр загварын үед ерөнхийдөө адил боловч хийсэн материал, хээ угалзаараа зэрэг дэсийн ялгаатай байсан ба Манж Чин, Богд хаант засгийн үед хэрэглэгдэж байсан дээлэнд хээ угалз хатгаж, тэмдгээр түшмэдийн зэрэг дэвийг ялгах ялгамж болгодог ёс энэ үед нэгэнт тогтоод байжээ.

Мөн түүнчлэн язгууртны алба ямбаны хувцас, харц ардын эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн дээлний загвар, хийц, материал зэргийн нийтлэг шинж болон ёслол хүндэтгэлийн зан үйлд оролцоходоо гоёж чимэглэх нийтээр хүлээн зөвшөөрсөн хувцас заслын нарийн дэг тогтсон байсан нь археологийн олдворуудаар нотлогдож байна.

## Ашигласан материал

- Батчулуун, Л. (1999). *Монгол эсгий ширмэлийн урлаг*. Улаанбаатар
- Батчулуун, Л. (1999). *Монгол эсгий ширмэлийн урлаг*. Улаанбаатар
- Баярсайхан, Ж. (2011) *Түүрүү үеийн тахилгын байгууламжууд //Жаргалантын амны буган хөшөөд*. Улаанбаатар
- Ганболд, Ж., Мөнхцэцэг, Т., Наран, Д., Пунсаг, А. (2011). *Монголын Юань улс*. Улаанбаатар
- Гантулга, Ж., Ерөөл-Эрдэнэ, Ч., Магай, Ж. (2016). *Хойд Тамирын буган хөшөө*. Улаанбаатар: Адмон принт ХХК
- Нямбуу, Х. (2002). *Монгол хувцасны түүх*. Улаанбаатар
- Сарантуяа, Н. (1999). *Урлаг дахь киноны тухай асуудалд // Монголын соёл урлаг судлал*. Улаанбаатар
- Саруулбуян, Ж., Энхтуяа, Л. *Монголчуудын хувцас*. Улаанбаатар